

БАТЛАВ.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ТАМГЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

**ТООН СУВГИЙН ТҮРЭЭСНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Ерөнхий зүйл

Энэхүү ажлын даалгавар нь Үндэсний аудитын газрын төв серверээс нийслэл болон 21 аймгийн Төрийн аудитын байгууллагуудын хооронд интернэт болон IPSec VPN tunnel-ээр мэдээлэл дамжуулах холболтын тоон сувгийн болон интернэтийн урсгалын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

№	Техникийн тодорхойлолт
1	Аймгийн төвүүдэд байрлах Захиалагчийн байршилд дэд бүтцийн шилэн кабелийг сүлжээнд холбож, тус бүр 50Mbps -ийн тоон суваг гаргах
2	Нийслэл дэх төрийн аудитын байгууллагын байршилд дэд бүтцийн шилэн кабелийн сүлжээнд холбох 80Mbps -ийн тоон суваг гаргах
3	Сүлжээний 24/7 зарчмаар ажилладаг хяналт удирдлагын нэгдсэн төвтэй байх бөгөөд Улаанбаатар болон орон нутгийн салбаруудад асуудал гарсан тохиолдолд нэн даруй шийдэх чадамжтай байх. Шилэн кабель, Холболтын төгсгөлийн төхөөрөмж, сүлжээний замчлагч төхөөрөмжид гэмтэл, саатал гарсан үед түргэн шуурхай сервис үйлчилгээ хийж өгөх инженер томилж бэлэн байдал хангасан байх
4	Орон нутагт төлөөлөгчтэй байх бөгөөд сүлжээ, дэд бүтцэд гэмтэл гарсан тохиолдолд 8 цагаас хэтрэхгүй шийдвэрлэдэг байх
5	Тоон сувгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан тоног төхөөрөмжийн тохиргоо, ашиглалт үйлчилгээг хариуцах
6	Гүйцэтгэгч нь логик түвшинд өөрийн суурь сүлжээ болон бусад тоон сувгийн үйлчилгээ авагчдын сүлжээнээс ялгах зорилготой L2/L3 IP MPLS бүхий суурь дэд бүтэцтэй байх
7	Төгсгөлийн төхөөрөмжүүдийг үнэ төлбөргүй ашиглуулах /төгсгөлийн хайрцаг, шилэн кабелийн хувиргагч төхөөрөмж г.м / . 1Gbps оптик интерфейс ашиглан харилцан холболт /ethernet/ хийх
8	Шилэн кабелийн үндсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангасан цагираг холболттой /ring/ байх
9	Үндэсний аудит төв серверийн дэд бүтэц, хэсэгтэй шилэн кабелийн шууд холболттой байх


10	Аль нэг чиглэлийн шилэн кабелийн сүлжээнд гэмтэл гарах үед автоматаар шилждэг нөөц шилэн кабелийн холболттой байх
11	Тоног төхөөрөмжид гарсан гэмтэл зэргээр нарийвчилж ангилж ирүүлнэ. <ul style="list-style-type: none"> • Шилэн кабельд гарсан гэмтэл • Сүлжээнд гарсан гэмтэл • Хэрэглэгчийн дуудлага ангилах • Дуудлагын шийдвэрлэлтийг захиалагчдад эргэн мэдээлэх
12	Гүйцэтгэгч нь аймаг, нийслэлд өөрийн байр цамхаг, худаг сувагчлалаар хангагдсан байх, захиалагчын байршилд тохируулан зураглалыг шинэчлэн гаргах
13	Үйлчилгээний бэлэн байдлын түвшин (SLA) 99.99% хангаж ажиллах
14	Үндэсний аудитын газар, нийслэл болон харьяа 21 салбар нэгжийн IPsec VPN tunnel холболтыг үүсгэж суурилуулалт, тохиргоог хийж гүйцэтгэх
15	Мэдээллийн технологийн дэвшилтэд технологийн шийдлийг боловсруулах, нэвтрүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана
16	Холболт хийх шаардлагатай зардлыг үйлчилгээ үзүүлэх байгууллага хариуцна
17	Захиалагч талд сүлжээний ажиллагаа, зарчим, аюулгүй байдал, сүлжээний зөв зохион байгуулалт, сүлжээний дэвшилтэд технологи, хэрэглээ, VPN tunnel-ийн ажиллагаа, зарчим, тохиргоо, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулах
18	Нийлүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээнд кибер аюулгүй байдлын талаар технологийн шинэ арга хэрэгслийг хэрэгжүүлэх, хяналт хийх
19	Хөндлөнгийн аудитын шалгалтад хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх
20	Сүлжээний төхөөрөмжийн хоорондын зохион байгуулалт, холболт, тохиргооны ерөнхий болон дэлгэрэнгүй топологи зураг гаргах, түүний дагуу тохиргоонуудыг хийж, тохиргооны бичиг баримт, ерөнхий болон дэлгэрэнгүй топологи зургыг эх хувиар болон цаасан хэлбэрээр хүлээлгэн өгөх

ХЯНАСАН:

Мэдээллийн технологийн төвийн захирал


 /А.Уянга-Эрдэнэ/

Мэдээллийн технологийн төвийн менежер

 /Б.Оюунтуяа/

БОЛОВСРУУЛСАН:

Мэдээллийн технологийн төвийн
Сүлжээ хариуцсан шинжээч

 /Б.Ануудар/

2024 оны 02 дугаар сарын 23 өдөр